

Япон шуудан банкттай (Юүчо банк) харилцах гадаадын иргэн танаа

■ Та данс нээлгэх болон бусад төрлийн бүрдүүлэлтийн үед иргэншил, оршин суух статус, оршин суух хугацаа зэргээ нотлохын тулд ажилтанд өөрийн оршин суух үнэмлэхээ гарган үзүүлнэ үү.

- ※ Та оршин суух үнэмлэхээ шинэчлэн сольсон тохиолдолд ажилтанд урьдаар мэдэгдэнэ үү.
- ※ Дипломат ажилтан зэрэг Оршин суух үнэмлэх олгогдоогүй хүн бол үзүүлэх шаардлагагүй.

■ Таны оршин суух хугацаа нь данс нээлгэх хүсэлт гаргасан өдрөөс 3 сарын дотор дуусах бол та данс нээлгэх боломжгүй.

Та Японд үргэлжлүүлэн оршин суухаар төлөвлөж байгаа бол оршин суух хугацаагаа сунгасны дараагаар шинэ оршин суух үнэмлэхээ авчран данс нээлгэх хүсэлтээ гаргана уу.

- ※ Японы хилээр нэвтрэх үед зөвшөөрсөн оршин суух хугацаа нь 3 сараас дотогш бөгөөд Оршин суух үнэмлэх олгогдоогүй иргэнд Япон шуудан банк болон Шуудангийн газарт данс нээх боломжгүй.
- ※ Та оршин суух статус, оршин суух хугацаагаа шинэчлэн сунгаж байгаа бол сунгуулсныхаа дараа шинэ оршин суух үнэмлэхээ авчирна уу.

■ Оюутны үнэмлэх, компанийн ажилтны үнэмлэх зэргийг үзүүлнэ үү.

Оршин суух статус нь “留学(суралцах)” эсвэл “技能実習(Ур чадварын дадлага)”, бол сургуульд суралцаж байгаа болон компанид ажиллаж байгаагаа нотлохын тулд Оршин суух үнэмлэхийн хамтаар Оюутны үнэмлэх болон Компанийн ажилтны үнэмлэх зэргийг ажилтанд үзүүлнэ үү.

- ※ Сургууль болон компани руу Япон шуудан банк, Шуудангийн газраас утсаар холбогдох тохиолдол гардаг.

■ Данс нээлгэх хүртэл хугацаа шаардагдах тохиолдол гардаг.

Холбогдох хууль тогтоомжид үндэслэн, олон төрлийн баталгаажуулалтын улмаас хүсэлт хүлээн авсан өдрөө данс нээх боломжгүй бөгөөд дараа нь дансны дэвтрийг үйлчлүүлэгчийн гэрт шуудангаар хүргүүлэх тохиолдол гардаг.

Мөн зарим тохиолдолд данс нээхээс татгалзаж болно.

■ Бусад анхаарах зүйлс

- Таны гаргаж үзүүлсэн бичиг баримтыг хувилж авна.
- Таны гэрийн хаяг болон нэр өөрчлөгдөн, Оршин суух үнэмлэх шинэчлэгдсэн бол даруй шинэ оршин суух үнэмлээ авчран бүрдүүлэлт хийнэ үү.
- Авчраагүй тохиолдолд түр хугацаанд гүйлгээг хязгаарлаж болзошгүй.
- Хэрэв та түр оршин суугчаар бүртгүүлээд оршин суугчийн статус болгон өөрчлөн шинэчилсэн бол даруй банкны цонхонд ирж мэдэгдэнэ үү.
- Та эх орондоо буцах болон Японоос өөр улс руу нүүх бол заавал гэрээгээ цуцлан дансаа хаалгуулна уу.
- Гуравдагч этгээдэд ашиглуулах зорилготой данс (дансны дэвтэр болон карт) шилжүүлэх, худалдах, худалдан авах нь гэмт хэрэг болно. Огт бүү үйлдээрэй.

Нүүрэн хэсэг



Арын хэсэг



Эх сурвалж: Хилийн шалган нэвтрү ү лэх, оршин суух хяналтын газрын вэб сайт